

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШИХТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬД ЗААСАН  
ШАЛГУУРЫГ МӨРДҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.

**Хоёр. Шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавих ажиллагаа**

2.1. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан олон нийтэд хувьцаагаа санал болгон худалдсан төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч болох аливаа этгээд нь өөрийн болон холбогдох этгээд, улс төрд нөлөө бүхий этгээд, түүний хамаарал бүхий этгээдтэй хамааралтай эсэх талаарх мэдээллийг энэ журмын нэгдүгээр хавсралтаар тогтоосон маягтын дагуу үнэт цаасны брокерын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд (цаашид “үнэт цаасны брокер” гэх)-д үнэн зөв мэдүүлнэ.

2.2. Энэ журмын 2.1-д заасан мэдээллийг харилцагч үнэн зөв мэдүүлээгүй, эсхүл мэдүүлэхээс татгалзсан тохиолдолд үнэт цаасны брокер тухайн харилцагчид төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцааг худалдан авахтай холбоотой зуучлалын үйлчилгээ үзүүлэхгүй.

2.3. Үнэт цаасны брокер нь энэ журмын 2.1-д заасан мэдээллийг хүлээн авч, үйлчилгээ үзүүлэх явцад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан шалгуурыг тухайн харилцагч зөрчих нь илтэд тодорхой болсон бол харилцагчид хувьцаа худалдан авахтай холбоотой зуучлалын үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй.

2.4. Үнэт цаасны брокер нь энэ журмын 2.1-д заасан харилцагчийн талаарх мэдээллийг цахим хэлбэрээр үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд (цаашид “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” гэх)-д тухай бүр хүргүүлнэ.

2.5. Үнэт цаасны брокер нь энэ журмын 2.1-д заасан харилцагчийн талаарх мэдээллийг тогтмол шинэчилж, өөрчлөлтийг тухай бүр Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд хүргүүлнэ.

2.6. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь энэ журмын 2.4, 2.5-д заасны дагуу ирүүлсэн мэдээллийг нэгдсэн байдлаар бүртгэж, боловсруулах бөгөөд төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд болон улс төрд нөлөө бүхий этгээд, түүний хамаарал бүхий этгээдийн талаарх мэдээллийн нэгдсэн сантай байна.

2.7. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь энэ журмын 2.6-д заасны дагуу ирүүлсэн мэдээллийг нэгдсэн байдлаар бүртгэж, боловсруулах явцад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан шалгуурыг тухайн хувьцаа эзэмшигч зөрчиж байгаа нь тодорхой болсон бол ажлын 1 өдрийн дотор холбогдох мэдээллийг нотлох баримтын хамт Хороонд хүргүүлнэ.

2.8. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох болон ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргаснаас хойш ажлын 1 өдрийн дотор Хороонд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2.9. Хорооны Ажлын албанаас томилсон албан тушаалтан энэ журмын 2.6-д заасан мэдээллийн нэгдсэн санд нэвтэрч мэдээлэлтэй танилцаж, мэдээлэл цуглуулж болно.

2.10. Энэ журмын 2.9-т заасан албан тушаалтан нь мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй нууц мэдээллийг холбогдох хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй байх үүрэгтэй.

### **Гурав. Бусад**

3.1. Хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавих зорилгоор шаардлагатай тохиолдолд эрх бүхий төрийн байгууллагаас холбогдох мэдээллийг лавлах, тодруулах, гаргуулан авч болно.

3.2. Төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэл бүхий нөхцөл байдал үүссэн болон бусад шаардлагатай тохиолдолд Хорооноос эрх бүхий төрийн байгууллагад ажлын 3 өдрийн дотор мэдэгдэж, зохих арга хэмжээг авна.

“Төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцааг эзэмшихтэй холбоотой хуульд заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавих журам”-ын нэгдүгээр хавсралт

..... ТӨХК-ИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧИЙН ТОДОРХОЙЛОЛТ

<b>А.ТӨХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НЬ ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛ:</b>			
<b>Оноосон нэр:</b>			
<b>Улсын бүртгэлийн дугаар:</b>			
<b>Регистрийн дугаар:</b>			
<b>Байгуулагдсан огноо:</b>			
<b>Хуулийн этгээдийн улсын харьяалал:</b>			
<b>Үйл ажиллагааны чиглэл:</b>			
<b>Хаяг:</b>			
<b>Цахим хаяг:</b>			
<b>Холбоо барих утас:</b>			
<b>Хувь нийлүүлсэн хөрөнгө:</b>			
<b>Огноо</b>	<b>Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (төгрөгөөр)</b>	<b>Хувьцааны тоо ширхэг</b>	<b>Нэгж хувьцааны үнэ (төгрөгөөр)</b>
...			
<b>Нийт</b>			

<b>Холбогдох этгээдүүд:</b>				
	Овог, нэр/ Оноосон нэр	Регистрийн дугаар/ Бүртгэлийн дугаар	Ямар холбоотой болох	Эрхэлдэг ажил, албан тушаал/ Үйл ажиллагааны чиглэл
1				
2				
...				
<b>Улс төрд нөлөө бүхий этгээдүүд:</b>				
	Овог, нэр/ Оноосон нэр	Регистрийн дугаар/ Бүртгэлийн дугаар	Ямар холбоотой болох	Эрхэлдэг ажил, албан тушаал/ Үйл ажиллагааны чиглэл
1				
2				
...				

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргав.

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

(гарын үсэг)

(нэр)

..... оны ..... сарын .....-ний өдөр

**Б. ТӨХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НЬ ХУВЬ ХҮН БОЛ:**

Ургийн овог:		Сүүлийн зургаан сарын дотор авхуулсан өнгөт цээж зураг /цахим/
Овог:		
Нэр:		
Төрсөн огноо:		
Регистрийн дугаар:		
Иргэншил:		
Оршин суугаа хаяг:		
Цахим шуудангийн хаяг:		
Суурин болон гар утасны дугаар:		

**Холбогдох этгээдүүд:**

	Овог, нэр/ Оноосон нэр	Регистрийн дугаар/ Бүртгэлийн дугаар	Ямар холбоотой болох	Эрхэлдэг ажил, албан тушаал/ Үйл ажиллагааны чиглэл
1				
2				
...				

**Улс төрд нөлөө бүхий этгээдүүд:**

	Овог, нэр/ Оноосон нэр	Регистрийн дугаар/ Бүртгэлийн дугаар	Ямар холбоотой болох	Эрхэлдэг ажил, албан тушаал/ Үйл ажиллагааны чиглэл
1				
2				

...				
-----	--	--	--	--

Хувьцаа эзэмшигчийн иргэний үнэмлэх/паспортын хуулбарыг хавсаргав.

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан болно.

(нэр)

(гарын үсэг)

..... оны ..... сарын .....-ний өдөр